



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/479

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын а, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/03 тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орос-Монголын хооронд дипломат харилцаа үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй “Орос хэлний соёлын өдрүүд”-ийг тэмдэглэх арга хэмжээнд шаардагдах 3,306,100 (гурван сая гурван зуун зургаан мянга нэг зуу) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2.Дээрх 3,306,100 (гурван сая гурван зуун зургаан мянга нэг зуу) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101013

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 05-ны өдрийн А.479
дугаар захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Багц	үнэ	тоо ширхэг	нийт
Гарын бэлгийн тооцоо /аймгуудын оролцогчдод/				
	Аймаг	Хүүхдийн тоо	бэлгийн үнэ	бүгд
1	Баянхонгор	5	7000	35,000
2	Булган	5	7000	35,000
3	Хөвсгөл	5	7000	35,000
4	Архангай	2	7000	14,000
		багшийн тоо		
1	Баянхонгор	3	10000	30,000
2	Булган	3	10000	30,000
3	Хөвсгөл	2	10000	20,000
4	Архангай	3	10000	30,000
1	Аннос	1	85000	85,000
2	Стикер	1	40000	40,000
3	Матрёшка	1	40000	40,000
4	Урилга	37	3500	129,500
5	Зохион байгуулах комисст гарын бэлэг	7	40000	280,000
6	Удирдлагуудын хүрээнд хийх уулзалт			500,000
7	Сурагчдын бүтээлийн уралдааны шагнал	3	40000	120,000
8	Оройн хүлээн авалт	35,800	47	1,682,600
9	Зохион байгуулах комиссыг үдэх			200,000
	Нийт дүн			3,306,100